



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн
доод хэмжээг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэхээс бусад банк бус санхүүгийн үйл ажиллагаа шинээр эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ Улаанбаатар хотод 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан, Төв аймгийн Зуунмод суманд 1,200,000,000 (нэг тэрбум хоёр зуун сая) төгрөг, бусад аймаг, суманд 400,000,000 (дөрвөн зуун сая) төгрөгөөс багагүй байхаар тус тус тогтоосугай.

2. Банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг байхаар тогтоосугай.

3. Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ Улаанбаатар хотод 300,000,000 (гурван зуун сая) төгрөг, аймаг, суманд 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгөөс багагүй байхаар тус тус тогтоосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА  Т.ЖАМБААЖАМЦ



1518090134